

## **АСЕАН-НЫ ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ ИХ ГҮРНҮҮДИЙН БАЙР СУУРЬ, АШИГ СОНИРХОЛ**

*Б.Цэнгэлхам\**

*Уг өгүүлэлээр АСЕАН буюу Зүүн Азийн Улсуудын Холбооны жин нөлөө олон улсын тавцанд улам бүр өсөн нэмэгдэж байгаа энэ үед тус бус нутгийн байгууллагын талаар их гүрнүүдийн байр суурь, ашиг сонирхол ямар байгаа талаар гаргаж ирэхийг зорилоо. АСЕАН нь геополитикийн асар ач холбогдолтой байгууллага учир их гүрнүүд байр суурь, ашиг сонирхолоо байнга илэрхийлсээр байдаг. Эдгээр улсуудын ашиг сонирхол нь улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын асуудал дээр ихэвчлэн илэрдэг.*

### **АСЕАН-ны талаарх АНУ-ын байр суурь**

1977 онд Манила хотод АНУ АСЕАН-тай албан ёсны харилцаа тогтоосон ба 2007 онд харилцаа тогтоосны 30 жилийг тэмдэглэжээ.<sup>1</sup>

АСЕАН-ны эдийн засгийн өсөлтийн хурдац, улс төрийн идэвх, өөрийн орны цэрэг, улс төрийн сонирхлыг харгалзан АНУ энэ бүс нутгийн байгууллагыг ямагт дэмжсээр ирсэн юм. Онцгой нөхцөлд шаардлагатай цэргийн тусламжийг АНУ АСЕАН-ны орнуудад үзүүлдэг байжээ. АСЕАН-ны орнууд АНУ-тай нягт хамтран ажиллаж байгаа боловч бүс нутгийн эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагаа, НҮБ болон бусад байгууллагад хэлэлцдэг асуудлаар АНУ өөр байр суурьтай.<sup>2</sup> Худалдаа, эдийн засгийн харилцаа, үүний дотор худалдааны хориг хаалтыг сулруулах боломжийг бүхий л талаар судлах зорилготой “АНУ-АСЕАН-ны санаачлага”-ыг байгуулахаар анхаарах болжээ.

1990 оноос буюу “Хүйтэн дайн”-аас хойш АНУ-ын гадаад бодлогод зарим шинэ хандлагууд гарч ирсэн. Өмнө нь АНУ-ын Ази, Номхон далайн бүс нутаг дахь гол ашиг сонирхол нь цэрэг-стратегийн эсвэл улс төрийн байсан бол харин одоо эдийн засгийн ашиг сонирхол нь илт давамгайлах болжээ.<sup>3</sup> Нэн хурдан хөгжиж байгаа эдийн засагтай Ази, Номхон далайн бүс нутаг нь Америкийн худалдаа, санхүү, зах зээл, хөрөнгө оруулалтын ашиг сонирхлыг ихэд татдаг бүс нутаг болжээ. Хүн ам, газар нутгийн нөөц ихтэй, цөмийн зэвсэг бүхий хэд хэдэн улстай бүс нутагт хүчний тэнцвэрийг хадгалах, аюулгүй байдлыг хангахад АНУ-ын оролцоо чухал.<sup>4</sup> Мөн түүнчлэн, БНХАУ-ын эдийн засгийн боломж нь нэмэгдэхийн хэрээр цэргийн хүч нь нэмэгдэхээс сэрэмжилж байгаа нь АСЕАН-ны орнуудын, Спратлийн арлуудын зээмшлийн төлөөх өрсөлдөөнд БНХАУ-тай маргаантай байгаа Малайз,

\* Б.Цэнгэлхам - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Филиппин зэрэг хэд хэдэн орны тулгамдсан асуудлуудыг зохицуулах чухал хүчин зүйл нь Америкийн тэнцвэржүүлэх үүрэг гэж үзэх болжээ.<sup>5</sup>

АНУ, АСЕАН-ны эдийн засгийн харилцаа улам өргөжин бэхжсээр байна. 2006 онд АНУ АСЕАН-ны хоорондын гадаад худалдааны эргэлт 168 тэрбум ам.доллар байсан ба АСЕАН нь АНУ-ын худалдааны 4 дэх том түнш юм. Одоогоор АНУ-ын компаниуд АСЕАН-ны орнуудад бараг 90 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг хийгээд байна. 2006 оны 8-р сард АНУ-ын худалдааны төлөөлөгч Сьюзан Шваб АСЕАН-Америкийн хооронд худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт хамтран ажиллах зөвлөмж бичигт гарын үсэг зурсан ба хамтран ажиллах ажлын төлөвлөгөө нь энэ зөвлөмж бичиг дээр үндэслэгдэн явагдаж байна. 2006 оны 7-р сард Кондализа Райз АСЕАН-тай хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэлийн төлөвлөгөөнд гарын үсэг зурсан. Энэхүү төлөвлөгөө нь АНУ-АСЕАН-тай хамтран ажиллах бүх талын харилцааг зохицуулна. Мөн түүнчлэн, терроризм, хар тамхины наймаа, халдварт өвчин, хүрээлэн байгаа орчныг хамгаалах зэрэг олон улсын чанартай асуудлуудыг зохицуулахад хамтарч ажиллах юм.

2006 онд АНУ-ын Ерөнхийлөгч Ж. Буш АСЕАН-ны удирдагчидтай хамтран ажиллах үйл ажиллагааныхаа үндсэн 8 чиглэлийг баталсан.<sup>6</sup> Үүнд:

1. Эдийн засгийн хамтын ажиллагаа
2. Эрүүлийг хамгаалах
3. Сургалтын тэтгэлэг
4. Мэдээллийн технологи
5. Зам тээвэр
6. Эрчим хүч
7. Байгалийн гамшгийн хор уршгийг арилгах
8. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, зөв зохистой ашиглах зэрэг

болно.

Америкийн судлаачдын үзэж байгаагаар “Хятадын санаархал Америкийнхтай мөргөлдөж болох газар нутаг байсаар байна. Энэ нь тухайлбал, Зүүн Өмнөд Ази... зэрэг Хятад санаархлаа түүхийн танил арга буюу хүчтэй нударгаар хэрэгжүүлэх гэж оролдож болох газар юм. Бүр асар их хүчтэй Хятад ч эрхшээлдээ хялбархан оруулна гэхэд Зүүн Өмнөд Ази нь нөөц боломжоор дэндүү баян, газар зүйн хувьд маш урт сунамал байршилтай, ер нь хэтэрхий том боловч наад зах нь Хятадыг хүндэтгэх бүсэд хамаарахаас өөр аргагүй дэндүү сул, улс төрийн хувьд хэт тархай бутархай бүс нутаг юм. Энэ бүс нутгийн бүх улсад байдаг Хятадын санхүү, эдийн засгийн оролцоо түүний нөлөөг тэнд нэмэгдүүлэхэд дөхөм үзүүлдэг бөгөөд Хятадын хүч чадал чангарахын хэрээр тэр нөлөө заавал нэмэгдэнэ. Энэ хүчээ Хятад яаж ашиглахаас их зүйл шалтгаалах боловч Америкт түүнтэй шууд сөргөлдөх буюу Өмнөд Хятадын тэнгисийн маргаантай асуудал мэтэд оролцох ямар нэг тусгай сонирхол байгаа эсэх нь сайн тодорхойгүй байна.”<sup>7</sup>

### **АСЕАН-ын талаарх ОХУ-ын байр суурь**

ОХУ-ын гадаад бодлогын тэнцвэр нь Европ, Америк, Ази гэсэн 3 чиглэлийг зөв харьцуулсанаар бий болно. Азийн чиглэлд Хятад, Япон, Энэтхэг, Өмнөд болон Умард Солонгос, АСЕАН-ны орнууд оршиж байгаа бөгөөд эдгээр орныг Оросын дипломат ажиллагааны дэмжлэгээр одоо болон хэтдээ дэлхийн олон төвт бүтцийн гишүүд болгоод байгаагийн дээр тэдгээрийн зарим нь хувийн жингээрээ Европын орнуудын зах зээлтэй эн зэрэгцэхүйц болж байна.<sup>8</sup>

Бүс нутгийн эдийн засаг, улс төрийн уур амьсгалыг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй АСЕАН-тай харилцахад ОХУ ихээхэн анхаарч, идэвхтэй үйл ажиллагаа явуулсаар ирсэн билээ.

ОХУ-ын хувьд Ази, Номхон далайн бүс нутагт эдийн засаг, улс төр, цэргийн нөлөөгөө бэхжүүлэх сонирхлоо орхиогүй байгаа боловч бодит боломж нь хязгаарлагдмал хэвээр байна.<sup>9</sup>

АСЕАН-ны талаарх ОХУ-ын гол сонирхол нь Ази, Номхон далайн улс төр, аюулгүй байдлын олон талт яриа хэлцэлд ороход АСЕАН-ыг ашиглахад оршиж байна.<sup>10</sup> АСЕАН-ны Бүсийн Чуулганы анхны хуралдаанд оролцсон нь ОХУ-ын хувьд шинэ зүйл бөгөөд түүгээр дамжин Азийн аюулгүй байдлын асуудалд нөлөөлөх боломжтой болсон нь ОХУ-ын Азийн дипломат бодлогын нэг ололт нь байлаа.<sup>11</sup>

1992 оноос эхлэн ОХУ АСЕАН-ны яриа хэлэлцээрт, 1994 оноос АРФ-ын үйл ажиллагаанд оролцож эхэлсэн. 1997 оны дундаас АСЕАН-ОХУ-ын хооронд хамтран ажиллах хороо байгуулагдсан. АСЕАН-ОХУ-ын сангийн харилцааны яриа хэлэлцээрийн үйл ажиллагаа нь хоёр талын худалдаа, эдийн засгийн болон шинжлэх ухаан, технологийн асуудлуудын уялдаа холбоонд чиглэгддэг. АСЕАН, ОХУ-ын худалдаа, эдийн засгийн харилцаа, холбоо эрчимтэй хөгжиж байгаа ба 1992-1999 онд 21 тэрбум ам.доллараас<sup>12</sup> хол давжээ.

ОХУ-ын Вьетнам, Индонези, Малайз зэрэг АСЕАН-ны орнуудтай харилцдаг харилцаанд цэрэг дайны техникийн хамтын ажиллагаа тодорхой байр суурь эзэлдэг. ОХУ-ын АСЕАН-ны орнууд дахь санхүүгийн сонирхол нилээд давамгайлж байгаа гэж хэлж болно.

### **АСЕАН-ны талаарх БНХАУ-ын байр суурь**

Хятад улс АСЕАН-ны бүх гишүүн оронтой дипломат харилцаа тогтоож, 1996 онд АСЕАН-ны тал бүрээр яриа хэлэлцээ хийгч түнш болжээ.

Аливаа улсын гадаад бодлого, тулгамдсан асуудлууд нь цаг үе, олон улсын байдалтай холбоотойгоор өөрчлөгдөж байдаг хэдий ч Зүүн Өмнөд Азийн талаар баримталж буй Хятадын бодлого хэвээр үргэлжилсээр иржээ. Хятадаас Зүүн Өмнөд Азид явуулж байгаа бодлого бүр хэдэн зуун жилийн тэртээх феодалын үеийн “хятад төв”-ийн бодлогыг өвөлснөөрөө онцлогтой юм.<sup>13</sup>

*10+1 > 11*: БНХАУ-ын гадаад бодлогын чиглэлд “Сайн хөрш”-ийн гадаад бодлогыг баримталж, хөрш зэргэлдээ улс орон, бүс нутагтай харилцан ашигтай байх тогтолцоог бий болгох хэмээн тусгасан байдаг ба энэхүү чиглэлийн хүрээнд

БНХАУ нь бүс нутгийн олон талт механизм бий болгоход идэвхтэй оролцдог. Жишээ нь, ШХАБ, Хятад ба АСЕАН-ы харилцаа. Ялангуяа АСЕАН+1 механизмыг илүү чухалчлан авч үздэг. Энэ харилцаанд эдийн засгийн ашиг сонирхол давамгайлдаг гэж хэлж болно.

10+1>11 томъёоллыг Хятад улс гаргаж ирэн өргөнөөр хэрэглэж байна. Энэ томъёоллын гол утга нь АСЕАН-ны 10 орон дээр ямар нэгэн улс шинээр гишүүнчилж 11 гишүүнтэй боллоо ч тэр нь АСЕАН+1 буюу АСЕАН+Хятад механизмаас хэзээ ч илүү байж чадахгүй гэсэн санаа аж.

Одоогийн төлөвлөснөөр 2010 он гэхэд *Хятад+АФТА=САФТА*<sup>14</sup> гэсэн чөлөөт худалдааны бүс байгуулах<sup>15</sup> зорилготой. Хэрэв тэгж чадвал НАФТА, ЕХ, САФТА гэсэн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанууд дотор САФТА тэргүүлэх хэмжээнд хүрч чадна. Учир нь 2 тэрбум хүн амтай, 14 сая хавтгай дөрвөлжин км талбайтай байх бөгөөд ДНБ нь 4-5 мянган тэрбум ам.долларт хүрнэ гэж Хятадын эрдэмтэд тооцоолж байна<sup>16</sup>. 2005 оны 7-р сард АСЕАН Хятад 2-ын хооронд ТIG (Trade in Goods) гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний ач холбогдол нь өмнө 9,5% байсан гадаад худалдааны эргэлтийг 2005 онд 23% буюу 130,5 тэрбум ам.доллар болгож чадсан явдал юм.<sup>17</sup>

2003 оны 10-р сард АСЕАН, Хятад хоёр хоорондоо хөгжил цэцэглэлт, энх тайвны төлөө стратегийн түншлэлийн тухай тунхаглалд гарын үсэг зурсан.

Хятад бүс нутгийн улс орнуудтай АРФ-ын чуулгын хүрээнд идэвхтэй оролцож байна.<sup>18</sup>

Өмнөд Хятадын тэнгис дэх асуудал нь Зүүн Өмнөд Азийн дотоод ба гадаадын олон улс орнуудын анхаарлыг татаж байна. Өмнөд Хятадын тэнгис дэх бүрэн эрхт байдлын талаар маргаан нь бүс нутгийн энх тайван, аюулгүй байдалд заналхийлэх зэвсэгт мөргөлдөөнүүд болох хандлагатай. 1992 онд болсон АСЕАН-ны Гадаад хэргийн сайд нарын 25 дахь удаагийн уулзалтаар баталсан Өмнөд Хятадын тэнгис дэх тунхаглалд шууд холбоотой талуудын шийдвэрлэгч ба бүрэн эрхт байдлын тухай эмзэг асуудлуудыг тусгасан. Үндсэн зарчмууд нь маргаантай асуудлуудыг энх тайвны аргаар шийдвэрлэх, хүч үл хэрэглэх, шийдвэрлэх арга хэмжээнд шаардлагатай арга хэмжээнд таатай уур амьсгал бүрдүүлэхийн тулд холбогдогч талууд тогтоон барих шаардлагатай, холбогдогч улс оруудын шийдвэрлэх эрх ба бүрэн эрхт байдалд хохирол учруулахгүй байх, 1976 оны Балийн гэрээний зарчмуудыг Хятадын Өмнөд тэнгис дэх олон улсын “харьцах арга барил”-ыг цогцлоон байгуулах үндэслэл болгон ашиглах зэрэг юм.

Стратегийн байршил, байгалийн баялгаар элбэг учраас Өмнөд Хятадын тэнгисийн хувьд улс орнуудын ашиг сонирхол нь бүс нутаг, олон улсын харилцаанд эмзэг асуудал ба ирээдүйд ямагт сэтгэл зовоосон зүйл хэвээр байх болно. Стратегийн түншлэлийг бэхжүүлэх талаар АСЕАН, Хятадын хооронд үйл ажиллагааны хөтөлбөрийг 2004 оны 11-р сард Лаос улсад болсон АСЕАН-ны Дээд хэмжээний 10 дахь удаагийн уулзалтаар баталсан.<sup>19</sup> Энэ үед АСЕАН-Хятадын хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан юм. Урьдчилсан тооцоогоор энэхүү хэлэлцээр нь АСЕАН-аас Хятадад хийх экспортын хэмжээг

48%-иар, Хятадаас АСЕАН-д хийх экспортын хэмжээг 55,1%-иар нэмэгдүүлнэ.<sup>20</sup> 2005 оноос эхлэн АСЕАН, Хятад 2 Япон, Солонгостой чөлөөт худалдааны бүс байгуулах тухай яриа хэлэлцээр хийхээр төлөвлөж байна. 2005 оноос Хятад АСЕАН-Хятадын хамтын ажиллагааны санд 5 сая ам.доллар хандивлах болсноо мэдэгдсэн бөгөөд хөдөө аж ахуй, цахилгаан холбоо, мэдээлэл технологи, ажиллах хүчийг хөгжүүлэх, Меконг мөрний сав газрыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон бусад салбаруудад АСЕАН-тай хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийг амласан амлалтаа дахин баталсан. Хөгжлийн санаачилга, Меконг мөрний эргийн сав газрыг хөгжүүлэх хамтын ажиллагаа зэргээр дамжуулан Хятадын талаас АСЕАН-ны интеграцийг ямагт дэмждэг. Энэхүү ажил нь маш үр дүнтэй хэрэгжиж байгаа бөгөөд АСЕАН Хятадын харилцаа сүүлийн 15 жилд эрчимтэй хөгжиж байгааг хэлэхэд таатай байна гэж БНХАУ-ын Ерөнхий сайд Вэнь Зябао 2005 оны 12-р сарын 12-нд Малайзын Куала Лампур хотод болсон АСЕАН-Хятадын 9 дэх уулзалт дээр хэлсэн үгэндээ цохон тэмдэглэсэн байдаг.

2002 онд АСЕАН-аас Хятад руу экспортын барааны эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 31.2 тэрбум ам.доллар буюу 34.4%-иар өсч, Хятадаас АСЕАН-д экспортын барааны эргэлтийн хэмжээ 23.5 тэрбум ам.доллар буюу 28.3%-иар өссөн байна.

Тэдний хооронд гадаад худалдаанаас гадна хөрөнгө оруулалтыг харилцан бие биедээ хийх сонирхол ихээхэн байдаг ба энэ нь бодит байдал дээр ч маш амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал, 2005 оны байдлаар Хятад АСЕАН-д 1,08 тэрбум ам.долларын, харин 2004 оны байдлаар АСЕАН-ны орнуудаас Хятадад нийт 72,32 тэрбум ам.долларын буюу БНХАУ-ын гадны хөрөнгө оруулалтын 6.6%<sup>21</sup>-тай тэнцүү хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байна.

БНХАУ АСЕАН-ны орнуудтай зөвхөн эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд анхаарал хандуулж байгаагаас гадна тэдний хооронд улс төрийн найрсаг харилцаа хэдийнээ бий болжээ. Үүний тод жишээ нь Хятадын үе үеийн тэргүүнүүдийн АСЕАН-ны 10 оронд хийсэн айлчлалууд юм. Тухайлбал, Хятадын Төрийн тэргүүн Ян Шанкунь, Зян Земинь, Ху Жинтао, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн, Жу Рунзи, Вэнь Зябао нар АСЕАН-ны гишүүн 10 оронд улс төрийн болон албан ёсны найрсаг айлчлал удаа дараа хийж байжээ.<sup>22</sup> АСЕАН Хятадын хооронд улс төр, эдийн засгийн харилцаа эрчимтэй хөгжиж байгаа нь тэдний нийгэм, эдийн засгийн хөгжилд болон Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдалд ихээхэн ач холбогдолтой юм.

### **АСЕАН-ны талаарх Япон улсын байр суурь**

Зүүн Өмнөд Азийн газар зүйн нэгдмэл байдал дээр АСЕАН аль хэдийнээ амжилт олсон боловч эдийн засгийн нэгдмэл байдал дээр амжилт олж төдийлэн чадаагүй байгаа нь хуучин, шинэ гишүүн орнуудын хооронд байгаа эдийн засгийн асар их зөрүүтэй байдлаас харагдаж байна.<sup>23</sup>

“Хүйтэн дайн” дуусгавар болсноор бүх улс үндэстнүүд өөрсдийн стратегийг засварлан өөрчлөх шаардлагатай болсон. Хэрэв улс гүрнүүдийн улс төрийн аюулгүй байдал, батлан хамгаалах хүйтэн дайны үеийнх шиг хамгийн анхаарал татсан асуудал хэвээрээ байсан бол эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн чадамж нь шинэ зуунд шилжин орох шаардлага хангахгүй байх байсан. “Хүйтэн дайн” дуусахтай хамт шинжлэх ухаан, технологийн шуурга ялангуяа мэдээллийн технологи, зах зээлийн эдийн засаг эрчимтэй хөгжиж эхэлсэн нь улс үндэстнүүд эдийн засгийн аюулгүй байдлаа дахин авч үзэхэд хүргэсэн. Энэ нь өөрийн орны эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалъя гэвэл өөр орны эдийн засгийн аюулгүй байдлыг анхаарахгүй байж хэрхэвч болохгүй гэсэн үг юм.<sup>24</sup> “Хүйтэн дайн”-ы үеийн 40 гаруй жилд Япон улс үндсэндээ Америкийн батлан хамгаалахын аюулгүй байдлыг хамгаалах шүхрийн дор өөрийн орны эдийн засгийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж байсан гэж хэлж болно. “Хүйтэн дайн”-ы дараа хэдийгээр Америкийн хараанд үндэсний аюулгүй байдлын асуудлаа зохицуулдаг хэвээр байсан ч олон улсын байдал өөрчлөгдөхийг даган Япон улс эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалах бодлогоо өөрчлөх шаардлагатай болов. Өөрчлөх шаардлагатай чухал чиглэлүүдийн нэг нь АСЕАН. АСЕАН-тай эдийн засгийн тал дээр хамтарч ажилласнаар Япон улсын эдийн засгийн аюулгүй байдлаа сахин хамгаалах нэг үндэс болно гэж үзжээ.

1977 онд Ерөнхий сайд Фукуда АСЕАН-тай харилцахдаа баримтлах гадаад бодлогоо Япон энх тайвны төлөө тэмцэнэ, Зүүн Өмнөд Азийн орнуудтай найрсаг, харилцан итгэсэн харилцаа тогтооно, тэгш эрхт түншийн байр сууринаас АСЕАН-ны орнуудтай идэвхтэй хамтран ажиллаж, Зүүн Өмнөд Азийн бүс нутагт энх тайван, хөгжил цэцэглэлтийн бүтээн байгуулалтад оролцоно гэж тодорхойлжээ.<sup>25</sup> Өнгөрсөн хугацаанд Японоос АСЕАН-ны гишүүн орнуудад өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх төвүүдийг байгуулж, сургалтын ажлыг явуулахад эрчимтэй анхаарч байна.

Япон улс дэлхийн эдийн засгийн тэргүүлэгч том гүрэн, олон улсын тавцанд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг орны хувьд гадаад бодлогын үзэл баримтлалаа “Энх тайвныг цогцлоох гадаад бодлого”<sup>26</sup> хэмээн нэрлэж, дэлхий дахинд энх тайвныг цогцлооход хувь нэмрээ оруулахыг зорьж байна.

Ази тив дэх гадаад харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх бодлогын хүрээнд Азийн бүхий л улс орнуудтай тогтвортой байдал, хөгжил дэвшлийн үндэс суурийг тавихад чиглэсэн идэвхтэй бодлого баримталж байгаа ажээ. Япон Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд АСЕАН-ны орнууд чухал байр суурь эзэлдэг бөгөөд “АСЕАН-ны орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа улам бүр гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулахад анхаарч ажиллана” хэмээн заажээ.<sup>27</sup> АСЕАН-ны орнуудын хөгжилд Япон Улс үнэлэхүйц хувь нэмэр оруулсны үр дүнд тухайн бүс нутгийн орнууд хөгжлийн шатандаа амжилттай орсон гэж судлаачид дүгнэдэг байна.

Япон нь АСЕАН-ны гишүүн орнуудын худалдааны хамгийн том түнш бөгөөд Японтой хийж буй худалдаа АСЕАН-ны нийт худалдаа эргэлтийн 30%-аас илүү байна.<sup>28</sup> Өөрөөр хэлбэл, АНУ-тай хийж буй худалдаанаас илүү байна гэсэн үг. 1951 оноос Япон Зүүн Өмнөд Азийн бүс нутагт хөрөнгө оруулж эхэлсэн бөгөөд ийм учраас Японы улс төрийн нөлөө тус бүс нутагт нилээд нэмэгдэх хандлагатай байгаа хэдий ч АСЕАН-ны зарим тэргүүнүүд Японыг шүүмжилдэг байсан (тухайлбал, Махатир, Ли Руанн г.м.) ба одоо ч энэ уур амьсгал хэвээрээ.

### **АСЕАН-ны талаарх БНСУ-ын байр суурь**

БНСУ нь АСЕАН+3, АСЕАН+1 хамтын ажиллагааны механизмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог ба Солонгос-Сингапурын Чөлөөт худалдааны бүс байгуулан амжилттай хэрэгжүүлж байна.

2007 оны 11-р сарын 21-нд Сингапурт “АСЕАН+Солонгос”-ын 11 дэх Дээд хэмжээний уулзалт болсон<sup>29</sup> ба уг уулзалтанд оролцсон Солонгосын Ерөнхийлөгч АСЕАН-Солонгосын Төв байгуулах тухай санамж бичигт гарын үсэг зурахад бэлэн болсон гэдгээ мэдэгдсэн байна. Солонгос АСЕАН-ны Дэд хэмжээний уулзалтанд оролцоод 10 жил болж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд улс төр, эдийн засаг, соёлын зэрэг бүхий л салбарт идэвхтэй хамтын ажиллагаа өрнүүлжээ.

АСЕАН-ны бүс нутгийн эдийн засгийн ялгааг багасгахын тулд 5 сая ам.долларын тусламж олгох, АСЕАН-ны гишүүн орнуудтай хоёр талын хамтын ажмллагааг өргөжүүлэхэд Солонгос анхааран ажиллаж байна. Бүс нутгийн эдийн засгийн ялгааг багасгахын тулд мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, Зүүн Азийн улсуудтай зө эвтэй байхын тулд соёл урлагийн арга хэмжээнүүдийг харилцан зохион байгуулах шаардлагатай байгааг Солонгосын тал байнга илэрхийлдэг ажээ.

### **ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ**

1. <http://usinfo.state.gov/russian/>
2. Хулан. Х., “Ази, Номхон далайн бүс нутаг дахь АНУ-ын бодлого: Залгамж чанар, шинэ зүйл”, *Дорно Дахины Судлалын Асуудал*, 1990, №1, 34-р тал.
3. Батбаяр, Ц., “Ази, Номхон далайн бүс нутаг 90-ээд онд”, *1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол Улс-Их гурнуудийн харилцаа*, Улаанбаатар, 1995, 9-р тал.
4. Цолмон, Д., *Америкийн Нэгдсэн Улсын түүх*, Улаанбаатар, 2007, 350-р тал.
5. Батбаяр, Ц., “Ази, Номхон далайн бүс нутаг 90-ээд онд”, *1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол Улс-Их гурнуудийн харилцаа*, Улаанбаатар, 1995, 7-р тал.

6. <http://usinfo.state.gov/russian/>
7. Бжезинский, З., *Шатрын аварга хөлөг*, Улаанбаатар, 2003, 193-р тал.
8. Нямдолжин, А., *Оросын Холбооны Улсын Ази, Номхон далайн бүс нутагт явуулж буй гадаад бодлого*, Улаанбаатар, 1999, 13-р тал.
9. Дашцэвэл, С., *Зүүн Өмнөд Азийн хөгжлийн хандлага, интеграци, Монгол Улсын бодлого чиглэл*, Улаанбаатар, 2005, 90-р тал.
10. Төмөрчулуун, Г., “ОХУ-ын Зүүн Азийн бодлого”, *1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол Улс-Их гурнуудийн харилцаа*, Улаанбаатар, 1995, 32-р тал.
11. Мөн тэнд, 33-р тал.
12. <http://www.asean.ru>
13. Пунцаг, Э, Сувд, Ч., Хятадаас “Зүүн Өмнөд Азид явуулж буй бодлого: Эрт, эдүгээд”, *Дорно дахины судлалын асуудал*, 1984, №1, 14-р тал.
14. <http://www.aseansec.org>
15. <http://www.mofa.gov.vn>
16. Төмөр, Н., “БНХАУ, АСЕАН-ны орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа”, *Олон улс судлал*, Улаанбаатар, 2007, №2, 51-р тал.
17. <http://www.moste.gov.vn>
18. <http://www.mofa.gov.vn>
19. <http://www.mofa.gov.vn>
20. <http://www.mofa.gov.vn>
21. Төмөр, Н., “БНХАУ, АСЕАН-ны орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа”, *Олон улс судлал*, Улаанбаатар, 2007, №2, 52-р тал.
22. Мөн тэнд, 51-р тал.
23. *An ninh kinh te ASEAN va vai tro cua Nhat Ban* (АСЕАН-ны эдийн засгийн аюулгүй байдал ба Японы үүрэг роль), Ханой, 2001, tr.302.
24. Trong cuon sach nay, tr.274.
25. Оюунгэрэл, О., “Япон ба Ази, Номхон далайн бүс нутаг”, *1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол Улс-Их гурнуудийн харилцаа*, Улаанбаатар, 1995, 52-р тал.
26. <http://www.mofa.go.jp>
27. <http://www.mofa.go.jp>
28. Дашцэвэл, С., *Зүүн Азийн хөгжлийн хандлага, интеграци, Монгол Улсын бодлого чиглэл*, Улаанбаатар, 2005, 91-р тал.
29. <http://www.president.go.kk>